# БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Булган аймгийн Хангал сумын хүүхдийн цэцэрлэг 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2026/149/НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Булган аймаг<br>2026 он | Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт<br>Утас 70342580 Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn<br><br>Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, аудитын менежер: Ж.Энхцоодол<br>Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn<br><br>“Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын захирал:Д.Мягмарсүрэн<br>Утас: 99030170 Цахим хаяг: dalaivan.et@gmail.com<br><br>“Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын Аудитор: Б.Пүрэвсүрэн<br>Утас: 99921600 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1. Хараат бус аудиторын дүгнэлт ........................................................................................
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................................
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.........................................................................................
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....................................................................................
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ...................................................................................
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал...........................................................................
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .......................
4. Аудитын тайлан ..........................................................................................................................
4.1 Ерөнхий зүйл ...........................................................................................................................
4.2 Материаллаг байдал ...............................................................................................................
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт..................................................................................
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .........................
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .................................................
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..................................................................................
5. Аудитын илрүүлэлт .....................................................................................................................
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл ..................................................................

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар |
| ЗДТГ | Засаг Даргын Тамгын Газар |

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс:7034-2580
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2026.02.24. № 219

танай________ны №________т

ХАНГАЛ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.ГЭРЭЛЧИМЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хангал сумын Цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хангал сумын Цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, заавары н дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Хангал сумын Цэцэрлэг нь 2025 онд 70 хүүхэдтэй үйл ажиллагаа явуулан гүйцэтгэлээр санхүүжсэн. Тайлант онд орон нутгийн хөгжлийн сангаас 19,800 мянган төгрөгийн "Сургалт хөгжлийн стем хөтөлбөрийн тоглоом" Аймгийн Засаг даргын тамгын газраас 1,300.0 мянган төгрөг пазал тоглоом " эцэг эхийн хандиваар 2,208.0 мянган төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүн болон ахуйн хэрэглэл, 65.0 мянган төгрөгийн огурцы зэргийг бараа материалын данс бүртгэлд бүртгэсэн. Сумын Засаг даргын тамгын газраас 1,400.0 мянган төгрөг Зуслангийн газар мөн 5,000.0 мянган төгрөгийн гадна Эко модон хүүхдийн тоглоомын талбай, 1,200.0 мянган төгрөгийн гадна явган хүний зам зэргийг үндсэн хөрөнгийн дансанд үнэ төлбөргүй хөрөнгийн орлогоор санхүүгийн тайланд тусгасан.

**Аудитын гол асуудал**

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор "Цалин хөлс шинэчлэн батлах тухай" төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоосон байна.

Боловсролын ерөнхий газрын 2025 оны 01 сарын 23-ны 1/383 албан тоотоор 2024-2025 оны хичээлийн жилд сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэвийн үйл

0326050262

ажиллагааг хангахтай холбоотойгоор 2025 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, төсвийн хөрөнгийн ашиглалтын үр дүнг сайжруулах, зөв зохистой удирдах, өр, авлага үүсгэхгүй байх зарчмыг баримтлан ажиллахыг чиглэл болгосон байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр нийт 5 зорилтын хүрээнд 64 арга хэмжээ хэрэгжүүлж ажиллан 85.9 хувьтай дүгнүүлсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТЦОГТ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Эхний үлдэгдэл | 2. Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 124,988,691.86 | 109,617,286.66 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 40,358,266.79 | 9,681,743.79 |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 40,358,266.79 | 9,681,743.79 |
| 31210 | Төгрөг | 40,358,266.79 | 9,681,743.79 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 40,358,266.79 | 9,681,743.79 |
| 33 | АВЛАГА | 0.0 | 1,559,000 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 0.0 | 1,559,000 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 84,630,425.07 | 98,376,542.87 |
| 35100 | Түүхий эд материал | 1,602,320 | 536,400 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 1,602,320 | 401,400 |
| 35130 | Эм боох материал | 0.0 | 135,000 |
| 35400 | Хангамжийн материал | 80,456,105.07 | 97,840,142.87 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,662,470 | 2,230,720 |
| 35420 | Аж ахуйн материал | 32,781,220 | 30,761,392 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 220,000 | 220,000 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 27,000 | 0.0 |
| 35450 | Барилгын засварын материал | 2,779,500 | 7,257,077 |
| 35460 | Хүнсний материал | 7,039,116 | 7,659,754.8 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 37,518,799.07 | 49,711,199.07 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 348,824,101.20 | 341,395,193.48 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 348,824,101.20 | 341,395,193.48 |
| 39100 | Газар | 0.0 | 1,400,000 |
| 39200 | Биет хөрөнгө | 342,449,601.2 | 334,021,193.48 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 476,540,883.74 | 476,540,883.74 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -195,262,642.6 | -202,914,189.40 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 41,610,551 | 48,010,951 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -20,292,426.44 | -27,045,848.99 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 19,188,340 | 19,188,340 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -4,349,540.54 | -6,513,670.58 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 1,500,000 | 0 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -1,350,000 | 0 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 34,027,792 | 36,977,792 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -10,151,866.96 | -11,211,575.29 |
| 39217 | Ном | 988,511 | 988,511 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 5,974,000 | 5,974,000 |

| | | | |
|---|---|---|---|
| 39301 | Програм хангамж | 1,350,000 | 1,350,000 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,350,000 | -1,350,000 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 5,974,000 | 5,974,000 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2 | 470,840,293.06 | 451,012,480.14 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 0.0 | 250,403.69 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 0.0 | 250,403.69 |
| 41300 | Өглөг | 0.0 | 250,403.69 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 0.0 | 119,283.69 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 0.0 | 131,120 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 470,840,293.06 | 450,762,076.45 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 470,840,293.06 | 450,762,076.45 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 48,459,790 | 48,459,790 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 48,459,790 | 48,459,790 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 354,960,527.11 | 331,909,810.50 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 354,960,527.11 | 354,960,527.11 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.0 | -23,050,716.61 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 70,392,475.95 | 70,392,475.95 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5 | 473,812,793.06 | 451,012,480.14 |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**/Төгрөгөөр/**

| **Дансны код** | **Дансны нэр, төрөл** | **1. Өмнөх он** | **2. Тайлант он** |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 332,163,760.94 | 437,107,238.27 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 55,162,935.8 | 437,107,238.27 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 55,162,935.8 | 30,973,500 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 47,061,690 | 7,600,000 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 8,101,245.8 | 23,373,500 |
| 122 | Тусламжийн орлого | 0.0 | 375,818,300 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | 0.0 | 375,818,300 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | 0.0 | 375,818,300 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого\\ | 0.0 | 375,818,300 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого\\ | 0.0 | 61,288,938.27 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 293,718,600 | 0.0 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 293,718,600 | 0.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 293,718,600 | 0.0 |

| | | | |
|---|---|---|---|
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 352,319,551.59 | 491,131,454.88 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 352,319,551.59 | 491,131,454.88 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 352,319,551.59 | 491,131,454.88 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 230,802,367.06 | 335,113,660.31 |
| 210101 | Үндсэн цалин | 152,621,109.05 | 205,071,865.96 |
| 210102 | Нэмэгдэл | 70,456,858.01 | 107,683,459.15 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.0 | 10,404,615.4 |
| 210104 | Урамшуулал | 7,724,400 | 11,953,719.8 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 29,842,309.02 | 38,430,809.98 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 20,340,100 | 26,144,916.31 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 2,393,000 | 3,079,163.8 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 1,196,400 | 1,539,549.36 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 1,196,400 | 1,489,617.36 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 4,716,409.02 | 6,177,563.15 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 30,645,460.94 | 32,733,938.27 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,465,768.94 | 6,384,242.27 |
| 210302 | Түлш, халаалт | 26,179,692 | 25,149,696 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,000,000 | 1,200,000 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 0.0 | 12,993,040 |
| 210401 | Бичиг хэрэг | 0.0 | 1,707,300 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 0.0 | 1,702,120 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 0.0 | 9,583,620 |
| 2105 | Нормативт зардал | 15,236,202.4 | 17,140,637.6 |
| 210502 | Хоол, хүнс | 15,236,202.4 | 17,140,637.6 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,799,700 | 28,555,000 |
| 210604 | Урсгал засвар | 7,799,700 | 28,555,000 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 477,800 | 1,615,000 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 477,800 | 1,615,000 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 75,960,873.11 | 28,538,545.72 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,726,617 | 9,587,838 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 840,628 | 2,671,900 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 69,393,628.11 | 16,278,807.72 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 428,516,773,47 | 491,131,454.88 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | -2,744,915.79 | -23,050,716.61 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 309,853.6 | 0 |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 309,853.6 | 0 |
| VII | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V) | -309,853.6 | 0 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | -3,054,769.39 | -23,050,716.61 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Өмнөх он | 2. Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 332,163,760.94 | 375,818,300 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 0.0 | 375,818,300 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 0.0 | 18,995,500 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 0.0 | 18,995,500 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0.0 | 18,995,500 |
| 122 | Тусламжийн орлого | 0.0 | 356,822,800 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | 0.0 | 356,822,800 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | 0.0 | 356,822,800 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого\\ | 0.0 | 356,822,800 |
| 122111 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 0.0 | 61,288,938.27 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 293,718,600 | 0.0 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 293,718,600 | 0.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 293,718,600 | 0.0 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 285,610,138.58 | 466,533,861.27 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 285,610,138.58 | 466,533,861.27 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 285,610,138.58 | 466,533,861.27 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 230,802,367.06 | 336,672,660.31 |
| 210101 | Үндсэн цалин | 152,621,109.05 | 206,630,865.96 |
| 210102 | Нэмэгдэл | 70,456,858.01 | 107,683,459.15 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.0 | 10,404,615.4 |
| 210104 | Урамшуулал | 7,724,400 | 11,953,719.8 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 29,842,309.02 | 38,311,526.29 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 20,340,100 | 26,144,916.31 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 2,393,000 | 3,079,163.8 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 1,196,400 | 1,539,549.36 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 1,196,400 | 1,489,617.36 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 4,716,409.02 | 6,058,279.46 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 30,645,460.94 | 32,733,938.27 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,465,768.94 | 6,384,242.27 |
| 210302 | Түлш, халаалт | 26,179,692 | 25,149,696 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,000,000 | 1,200,000 |
| 2105 | Нормативт зардал | 15,785,062.5 | 17,565,156.4 |
| 210502 | Хоол, хүнс | 15,785,062.5 | 17,565,156.4 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,799,700 | 28,555,000 |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 7,799,700 | 28,555,000 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 477,800 | 1,615,000 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 477,800 | 1,615,000 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,702,600 | 11,080,580 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,249,700 | 8,674,480 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,452,900 | 2,406,100 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 8,108,461.42 | -29,426,623 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 3,123,900 | 1,249,900 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 3,123,900 | 1,249,900 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 3,123,900 | 1,249,900 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 0.0 | 1,249,900 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 3,123,900 | 0.0 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -3,123,900 | -1,249,900 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 4,984,561.42 | - 30676,523 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 35,373,705.37 | 40,358,266.79 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 40,358,266.79 | 9,681,743.79 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**/Төгрөгөөр/**

| Дансны нэр, төрөл | 1. Устгалын өмнөх | | | |
|---|---|---|---|---|
| | 1.1 Засгийн газрын оруулсан капитал | 1.2 Дахин үнэлгээний нөөц | 1.3 Хуримтлагдсан үр дүн | 1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
| 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 48,459,790 | 70,845,060.95 | 357,562,711.5 | 476,867,562.45 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.0 | 0.0 | -1,826,815 | -1,826,815 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 48,459,790 | 70,845,060.95 | 355,735,896.5 | 475,040,747.45 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.0 | -452,585 | 0.0 | -452,585 |
| 1Тайлант үеийн үр дүн | 0.0 | 0.0 | -3,747,869.39 | -3,747,869.39 |
| 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 48,459,790 | 70,392,475.95 | 354,960,527.11 | 473,812,793.06 |
| 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 48,459,790 | 70,392,475.95 | 354,960,527.11 | 473,812,793.06 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 48,459,790 | 70,392,475.95 | 354,960,527.11 | 473,812,793.06 |
| Тайлант үеийн үр дүн | 0 | 0.0 | -23,050,716.61 | -23,050,716.61 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 48,459,790 | 70,392,475.95 | 331,909,81.50 | 450,762,076.45 |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/Төгрөгөөр/**

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Төлөвлөгөө | 2. Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 465,626,600 | 437,107,238.27 |
| 12 | Татварын бус орлого | 385,133,500 | 375,818,300 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 23,888,300 | 18,995,500 |
| 120010 | Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | 23,888,300 | 18,995,500 |
| 122 | Тусламжийн орлого | 361,245,200 | 356,822,800 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 361,245,200 | 356,822,800 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 80,493,100 | 61,288,938.27 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 424,696,100 | 406,494,823 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 424,696,100 | 406,494,823 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 424,696,100 | 406,494,823 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 347,606,400 | 336,672,660.31 |
| 210101 | Үндсэн цалин | 216,822,500 | 206,630,865.96 |
| 210102 | Нэмэгдэл | 120,807,400 | 107,683,459.15 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.0 | 10,404,615.4 |
| 210104 | Урамшуулал | 9,976,500 | 11,953,719.8 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 43,324,000 | 38,311,526.29 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,401,900 | 26,144,916.31 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,480,500 | 3,079,163.8 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,740,300 | 1,539,549.36 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,740,300 | 1,489,617.36 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,961,000 | 6,058,279.46 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 51,893,100 | 32,733,938.27 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,000,000 | 6,384,242.27 |
| 210302 | Түлш, халаалт | 42,393,100 | 25,149,696 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,500,000 | 1,200,000 |
| 2105 | Нормативт зардал | 19,778,100 | 17,565,156.4 |
| 210502 | Хоол, хүнс | 19,778,100 | 17,565,156.4 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 28,600,000 | 28,555,000 |
| 210604 | Урсгал засвар | 28,600,000 | 28,555,000 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,615,100 | 1,615,000 |

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,615,100 | 1,615,000 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,372,500 | 12,330,480 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,966,100 | 9,924,380 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,406,400 | 2,406,100 |
| 8 | ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | -39,562,600 | -30,676,523 |
| 9 | АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 39,562,600 | 30,676,523 |
| 7 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | 39,562,600 | 30,676,523 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.0 | 40,358,266.79 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.0 | 9,681,743.79 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,567.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 320.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 1,247.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага, материаллаг бус зөрчилд 1 зөвлөмж хүргүүлсэн байна.

***Залруулсан алдаа:***

- Санхүүгийн үр дүнгийн тайланд 15 500.0 мянган төгрөгийн урсгал засварын зардлыг, аж ахуйн материал, хангамжийн материал, сэлбэг хэрэгслийн зардалд гүйлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5."батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Сангийн сайдын 2023 оны 221 тушаалаар батлагдсан " ангилал шинэчлэн батлах тухай журам"-ын 2-р хавсралтын- Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал- зөрчигдсөн байна.

### 3.1 Төлбөрийн акт

<u>*Илрүүлэлт:*</u> Хүнсний материалын орлого зарлагын гүйлгээг тухай бүрт нь хийдэггүй, явцын аудитаар биет тооллого хийхэд 452.5 мянган төгрөгийн хүнсний материал дутагдалтай байгаа нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" 41 дугаар зүйлийн 41.2.7. "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" 5 дугаар зүйлийн 5.1.3."санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн 5 дугаар зүйлийн 5.1.4."үнэн зөв байх"; 5 дугаар зүйлийн 5.1.5."хэмжигдэхүйц байх" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### 3.2 Албан шаардлага

<u>*Илрүүлэлт:*</u> Тус цэцэрлэгийн эрхлэгч хөдөлмөр аюулгүй байдлын ажилтны албан тушаалыг 1 сар хавсран гүйцэтгэж 623.6 мянган төгрөгийн цалин авсан нь Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2."Ажил олгогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог, ажлын байрны эрсдэлийн түвшин, ажилтны тоог харгалзан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц болон ажилтан, зөвлөл ажиллуулна". 27 дугаар зүйлийн 27.4."Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтнаар инженер, техникийн болон эрүүл ахуйн боловсролтой, мэргэшсэн хүнийг ажиллуулна" гэсэн заалт зөрчигдсөн байна.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал***

<u>***Илрүүлэлт:***</u> Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн тэг үлдэгдэлтэй 47 035.3 мянган төгрөгийн анхны өртөгтэй 25 нэр төрлийн 98 ширхэг хөрөнгө бүртгэлтэй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3."холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн

стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах",ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.” гэсэн заалт зөрчигдөж байна.

***Өгсөн зөвлөмж***:

Холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллах

***1. Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал***

***Илрүүлэлт:*** Улсын цахим бүртгэлийн нэгдсэн системд 4739 м.кв газар эзэмших эрхийн үнэлгээг Санхүүгийн тайланд 3 504.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.1" үндсэн хөрөнгөд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодохын дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байх, техник, технологийн баримт бичгийг гүйцэд бүрдүүлсэн байх"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4."үнэн зөв байх", Засгийн газрын 2020 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 10-р тогтоолын 7 дахь заалт зэргийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

***Өгсөн зөвлөмж***:

Холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллах

***1. Зардлын данстай холбоотой асуудал***

***Илрүүлэлт:*** Цалингийн тооцооллоос үүссэн 1 559.0 мянган төгрөгийн ажилчдаас авах авлага, 119.3 мянган төгрөгийн татварын өглөгтэй тайлагнагдсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3."санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.8."төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

***Өгсөн зөвлөмж***:

Холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 6 дугээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| биет тооллого хийхэд 452.5 мянган төгрөгийн хүнсний материал дутагдалтай | 1 | 452.5 | **1** | 452.5 | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| хөдөлмөр аюулгүй байдлын ажилтны албан тушаалыг 1 сар хавсран гүйцэтгэж 623.6 мянган төгрөгийн цалин авсан | 1 | 623.6 | | | 1 | 623.6 | | | | | | |
| 4739 м.кв газар эзэмших эрхийн үнэлгээг Санхүүгийн тайланд 3 504.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан | 1 | 3,504.0 | | | | | 1 | 3,504.0 | | | | |
| 1 559.0 мянган төгрөгийн ажилчдаас авах авлага, 119.3 мянган төгрөгийн татварын өглөгтэй | 1 | 1,678.3 | | | | | 1 | 1,678.3 | | | | |
| тэг үлдэгдэлтэй 47 035.3 мянган төгрөгийн анхны өртөгтэй 25 нэр төрлийн 98 ширхэг хөрөнгө бүртгэлтэй | 1 | 47,035.3 | | | | | 1 | 47,035.3 | | | | |
| **Дүн** | **5** | **53,293.7** | **1** | **452.5** | **1** | **623.6** | **3** | **52,217.6** | | | | |